



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 1/06

Арвайхээр

г Эмнэлгийн орны ачааллыг зохицуулах тухай 7

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 358 дугаар тушаалын 2.3 дахь заалт, үндэслэн ТУШААХ нь:

1. БОЭТ-н хүүхдийн клиникт томуу томуу төст өвчнөөр өвчлөгсдийг эмчлэх зориулалтаар 2022-оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс өвчлөл буурах хүртэлх хугацаанд 90 орыг ковидын нөөц орноос шилжүүлэн дэлгэж ажиллуулсугай.

2. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслээр ханган ажиллахыг эм зүйч (Ж.Наранцэцэг), хүний нөөцийг зөв хуваарилан зохицуулалт хийж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (Л.Алтантөгс), сувилахуйн албаны дарга (Ц.Төмөрцоож), дайчлагдан ажиллагсдын илүү цагийн зардлыг журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг Санхүү эдийн засаг, хангамжийн албаны дарга (Г.Ганчөдөр)-т зөвшөөрсүгэй.

3. Нэмэлтээр дайчлагдан ажиллах хүний нөөцийг хавсралтаар баталсугай

4. Ариутгал, халдваргүйтгэл, халдварын эсрэг дэглэмд хяналт тавьж ажиллахыг Халдвараас сэргийлэх хяналтын албаны дарга (Г.Надмидсүрэн)-д даалгасугай.

5. Нэмэлтээр дэлгэсэн орны эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Хүүхдийн клиникийн эрхлэгч (М.Болормаа), асаргаа сувилгаа, цэвэрлэгээ үйлчилгээнд өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг ахлах сувиллагч (М.Гүндэгмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг эмчилгээ эрхэлсэн дэд захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Болормаа)-д даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны менежер (Ж.Нарантуяа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Э.ХҮДЭРЧУЛУУН